

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 14 цаг 07 минутад эхэлж, 14 цаг 47 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 47 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь Салбар зөвлөлийн 2014 оны 11, 13 тоот албан бичгээр ирүүлсэн санал хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>“Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 19 дүгээрт заасан Ховд аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний 4)“...Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга,” гэснийг “...Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,” гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Завхан аймаг</p>

		<p>дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны 08 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Пүрэвдоржийн Мөнхзаяаг томилох.</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 11 дугаарт заасан "...Арилдийн Мөнхцэцэг" гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга П.Мөнхзаяад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Орхон аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Х.Лувсаншаравыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1996-2000 онд Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгогдон ажиллаж байсан Хорчинжавын Лувсаншаравыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

4	Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт ажиллаж байгаа Ц.Билэгсүхээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн хяналтын газрын улсын байцаагчаар ажиллаж байсан Ц.Билэгсүхээс тус агентлагийн дэргэдэх Салбар зөвлөлийн “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” 2013 оны 28 дугаар тогтоолыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Албан тушаал бууруулах тухай” 2013 оны 1103 дугаар тушаалыг эрх зүйн чадамжгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. “Албан тушаал бууруулах тухай” 2013 оны 1103 дугаар тушаалыг хуульд нийцсэн шийдвэр мөн гэж шийдвэрлэсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” 2013 оны 28 дугаар тогтоолыг хүчингүйд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

